

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ АЖЛЫН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2024 оны 6 дугаар сарын 15

Номгон

"Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийг хэрэгжүүлж эхэллээ.

Хүүхдийг ивээх сан Япон улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх юм.

Энэхүү төслийг танилцуулах нээлтийн уулзалт 05 дугаар сарын 08-ны өдөр Баянхонгор аймагт болж, уулзалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүд болон төсөл хэрэгжих "Энхбүрд" өрхийн эрүүл мэндийн төв, 16-р цэцэрлэгийн удирдах ажилтнууд, эмч, багш нарын төлөөлөл оролцлоо.



Тус төсөл нь бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, тэдний хэрэгцээнд нийцсэн цогц дэмжлэгийг үзүүлэх зорилготой юм.

Уулзалтын төгсгөлд Хүүхдийг Ивээх Сан болон зорилтод өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэг хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, харилцан хүлээх эрх, үүргээ тодорхойллоо.





Баянхонгор аймагт шингэн бордооны туршилт, судалгаа, үйлдвэрлэлийн ажлыг эхлүүллээ.

Япон Улсын эрдэмтэн Ютака Хасегава, Өлзийт-ХАА МСҮТ-ийн захирал Б.Лхагвадорж болон бусад төлөөлөл шингэн бордооны туршилт, судалгаа, үйлдвэрлэлийн талаар аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан болон холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзаж санал солилцлоо.

Япон Улсын эрдэмтэн Ютака Хасегава нь шингэн бордооны судалгаа шинжилгээний ажлыг хийдэг бөгөөд Япон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шингэн бордоог үйлдвэрлэж зах зээлд гаргасан байна. Гэвч Япон болон Монгол орны хөрс, цаг уурын зөрүүтэй байдлаас шалтгаалан дээрхи шингэн бордоог манай орны хувьд шууд ашиглах боломжгүй тул Монгол орны хөрс, цаг уурт тохирсон шингэн бордоог үйлдвэрлэхээр Баянхонгор аймгийн Өлзийт-ХАА МСҮТ-тэй хамтран судалгаа, үйлдвэрлэлийн ажлыг эхлүүлээд байна.

Дээрхи шингэн бордоо:

- 1.Ойн аж ахуй
- 2.Хүнсний ногоо

3.Мал аж ахуйд зориулагдсан 3 янз байдаг ба ойн аж ахуйн бордоо нь ургамлын өнгө үзэмжийг сайжруулах, хүнсний ногооны бордоо нь газар тариалангийн хувьд хөрсийг тэтгэх, мал аж ахуйн бордоо нь малын бодисын солилцоог эрчимжүүлэх ач холбогдолтой.



Одоогийн байдлаар Өлзийт-ХАА МСҮТ нь Өлзийт сумын Бумбатад байх өөрийн талбайд туршилтын ажлыг эхлүүлээд байна. Цаашид хангайн бүсээс Жаргалант сум, говийн бүсээс Шинэжинст сумын Эхийн голыг түшиглэн туршилт судалгааны ажлыг хийхэд аймаг, орон нутгийн зүгээс дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийллээ.





Нүдний өвчний эрт илрүүлэг, нүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн мэдлэг, дадал олгох хөтөлбөр баянхонгор аймагт хэрэгжинэ.

Монголын нийт хүн амын хамгийн түгээмэл бэрхшээлийн нэг бол харааны асуудал байдаг. Энэ үүднээс алсын хараа муудах олон шалтгааныг эрт илрүүлж, эмчлэх замаар урьдчилан сэргийлэх эмчлэх боломжийг иргэд дээ олгож Баянхонгор аймаг Канад улсын Лаурел сан, Эрдэнэ ресурс, Эрүүл мэндийн яамтай хамтран нүдний өвчний эрт илрүүлэг, нүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн мэдлэг, дадал олгох цогц хөтөлбөрийг манай аймаг хэрэгжүүлэхээр болоод байгаа юм.

Энэ хүрээнд Канад Улсын Бритиш Колумбиагийн их сургуулийн профессор, Лаурел сангийн Монгол дахь төслийн зохицуулагч, доктор Хью Парсонсоор ахлуулсан ажлын хэсгийг Баянхонгор аймгийн Засаг даргын орлогч Б.Батсуурь, АЗДТГ-ын дарга Д.Энхжаргал нарын удирдлагууд хүлээн авч уулзан, зөвлөлдөх уулзалт хийлээ.

Баянхонгор аймгийн 20 суманд нүдний скринингийн чиглэлээр уг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр хүүхдийг үзлэгт хамруулах хувь хэмжээг өсгөх, иргэдийн болор цайх болон хараа муудах олон шалтгааныг эрт үед нь илрүүлж, эмчлэхэд чухал ач холбогдолтойг талууд уулзалтаар ярилцав.

Мөн нүдний арчилгааг хэрхэн хийх, хамгаалах талаар боловсрол нөлөөллийн ажлыг олон нийтийн дунд хүртээмжтэй олгосноор иргэд өөрсдөө нүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх маш том дадалтай болох юм.

Монгол улсад анх удаа нүдний эрүүл мэндийн үзлэгт хамрагдах уг хөтөлбөрийг Баянхонгор аймаг хэрэгжүүлснээрээ иргэдээ хараа муудах, сохрох өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх үндэс суурийг тавьж буйгаараа онцлог юм.





БНСУ-ын Жи Энержи компанитай дэд бүтэц, эрчим хүчний чиглэлээр хамтран ажиллахаар болов.

БНСУ-ын Жи Энержи компанийн төлөөлөл 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ажиллаж, аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан болон бусад албаны хүмүүстэй уулзалт хийлээ. БНСУ-ын J Energy компанийн төлөөлөл хэрэгжүүлэх төслийн танилцуулга дэлгэрэнгүй хийж, уулзалтын төгсгөлд талууд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.





1. Тус санамж бичгийг байгуулснаар Монгол Улсын гадаад хэргийн яам болон сангийн яамтай хамтарсан БНСУ-ын J Energy компанийн технологиор үйлдвэрлэсэн графен батерейны ESS хадгалах төхөөрөмжийг цахилгаан эрчим хүчээр хангахгүй байгаа газруудад нийлүүлж, цахилгаан эрчим хүч хэрэглэх боломж бүрдүүлэх утааг бууруулах
2. Эрчим хүч, барилга байгууламж, хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц, нийтийн барилга байгууламжийн чиглэлээр гадны хөрөнгө оруулалт татах, сүүлийн үеийн технологи, ноу-хау, шилдэг туршлага солилцох, суралцах, орон нутагт нэвтрүүлэх
3. Байгаль цаг уурн болон аливаа хүчин зүйлээс шалтгаалан эрчим хүч доголдох тохиолдолд гарч болох эрсдэлүүдийг бууруулах
4. Баянхонгор аймаг нь гэр хороолол ихтэй, утааны ялгаруулалтаараа улсад 2 дугаарт ордог тул айл өрхөөс гардаг утааг бууруулж, агаарын бохирдлыг багасгах
5. Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөл тархсан тул иргэдийг эрүүл орчинд ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх
6. Салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, албан хаагчдын мэдлэг ур

чадварыг дээшлүүлэх

7. Энэ хүрээнд салбаруудын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах ач холбогдолтой.

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА П.ОТГОНБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН
ГАДААД ХАРИЛЦААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН С.ЛХАМХОРОЛ